

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН 2 ДУГААР ХЭЛТСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ТӨЛӨВЛӨГӨӨТ ШАЛГАЛТ ЯВУУЛСАН ДҮНГИЙН ТУХАЙ

2017 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Ч.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн үйл ажиллагаанд 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс ажлын 10 хоногт төлөвлөгөөт шалгалт явуулж, шалган зааварчиллаа.

Шалгалт явуулсан дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2017 оны 04 дүгээр хуралдаанаар хэлэлцээд Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн үйл ажиллагаанд **61.3** оноо буюу “**Дутагдалтай**” гэсэн үнэлгээ өгч дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

1. Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн **14.612.845** төгрөгийн төлбөр, **96.919.851** төгрөгийн зөрчлийг илэрснийг хэлэлцүүлэн баталсан;

2. Тус цагдаагийн газрын тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэх, цаашид нэг мөр ойлгож хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга, /цагдаагийн хурандаа П.Батбаатар/-д 1, Нийслэлийн цагдаагийн газрын дарга, /цагдаагийн хурандаа Ж.Эрдэнэболд/-д 1, Хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн дарга /цагдаагийн дэд хурандаа Д.Сүрэн/-д 32 төрлийн үүрэг өгч тус тус даалгах;

3. Шалгалтаар Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулсан, ажлын байрны тодорхойлолтын үндсэн зорилтын зарим заалтыг хангалтгүй биелүүлж Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн 7 алба хаагчид Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2 дахь хэсэгт заасны дагуу албан тушаалын цалингийн хэмжээг 1-3 сарын хугацаагаар 20.0 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулах, 1 алба хаагчийг мөн хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.3 дахь хэсэгт заасны дагуу албан тушаал бууруулах, ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшлийн шаардлагыг хангаагүй 1 алба хаагчийн ажлын байрыг өөрчлөх;

4. Шалгалтаар заагдсан зөрчлийг засч, ажил сайжруулах чиглэлээр шалгалтын ажлын хэсгээс өгсөн 32 заалт бүхий үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж дүнг 2017 оны 06 дугаар сарын 20-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын хяналт шалгалт, үнэлгээ дотоод аудитын хэлтэст ирүүлэхийг Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн дарга, /цагдаагийн дэд хурандаа Д.Сүрэн/-д даалгахаар тус тус шийдвэрлэв.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС